

ТАНИЛЦУУЛГА

“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай”
Засгийн газрын тогтоолын төсөл
боловсруулсан тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн улсын дундаж цалин болон Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн дундаж цалинд тус тус үндэслэн Засгийн газар жил бүр тогтооно” гэж заасан.

Хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2017 оны “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг тогтоох тухай” 251 дүгээр тогтоолыг баталж, мөрдөж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, баталсан бөгөөд хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь албан журмаар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тус тус тэнцүү байна” гэж заасан.

Үүнтэй холбогдуулан “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсрууллаа.

“Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь сайн дураар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна” гэж заасны дагуу нийгмийн даатгалын сангийн орлого 8.8 тэрбум төгрөгөөр буурах тооцоолол гарсан бөгөөд Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн төсөлд энэхүү өөрчлөлтийг тусгасан.

Энэхүү тогтоол батлагдсанаар улсын болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй болно.

---oOo---